



БАТЛАВ.
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА А.ТЛЕЙХАН

2022 оны 02 сарын 25-дээр

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Хариуцах нэгж, албан тушаалтан
		Хугацаа	Хүрэх үр дүн	
Нэг. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:				
1.1	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах шаардлагатай албан тушаалтуудын 2021 оны ХАСХОМ-ыг тогтоосон хугацаанд нь гаргах, тайлан мэдээг зохих журмын дагуу гаргаж АТГ-т хүргүүлэх;	2-р сарын 25	Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийг хэрэгжүүлсэн байна.	ЗУГ М.Мөнхтулга холбогдох ажилтнууд
1.2	ЭХЗХ-ны бүтцийн нэгжүүдийн удирдлага, тусгай зөвшөөрөл, үнэ тариф, хяналт шалгалттай холбоотой мэргэжилтний сул орон тоонд болон аймгуудын Эрчим хүчиний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүнээр томилогодохоор нэр дэвшсэн иргэний Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСҮМ)-ийг АТГ-аар хянуулах, тус газраас хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох, эсэх асуудлыг шийдвэрлэх;	тухай бүр	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн дагуу үйл ажиллагаа явуулсан байна.	Хорооны дарга А.Тлейхан, АА-ны дарга Г.Эрхэмбаяр, ЗУГ М.Мөнхтулга
1.3	АТГ-аас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянахдаа давхар ажил эрхлэлтийн талаар өгсөн хязгаарлалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих;	тухай бүр	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн дагуу үйл ажиллагаа явуулсан байна.	ЗУГ М.Мөнхтулга Т.Батзаяа

1.4	Шинээр 2022 онд албан тушаалд томилогдох албан тушаалтан, ажилтнуудын болон их хэмжээний өөрчлөлттэй холбоотойгоор ХАСХОМ-ыг 30 хоногийн дотор гаргуулж ажиллах;	тухай бүр	Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн дагуу үйл ажиллагаа явуулсан байна.	ЗУГ М.Мөнхтулга
1.5	Хяналт шалгалт хийх, гэрээ байгуулах, тендерийн үнэлгээний хороонд ажиллах ажилтнуудаас ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл тайлбарыг гаргуулах, хяналт тавих, АТГ-ын цахим системд бүртгэх, зохих арга хэмжээг авч ажиллах;	тухай бүр	Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлеөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу үйл ажиллагаа явуулсан байна.	ЗУГ М.Мөнхтулга
1.6	Тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим хуулийн этгээдийн тарифыг Хорооноос хянаж тооцсон байдалд дотоод аудит хийх, зөвлөмж өгөх;	2, 4-р улирал	Эрчим хүчний үнэ тариф тогтоох үйл ажиллагаа нь холбогдох журам, аргачлалын дагуу хэрэгжсэн байна.	ДАГ Ч.Цоодол
1.7	Хорооноос зарим компаниудад тусгай зөвшөөрөл олгосон, нэмэлт өөрчлөлт оруулсан байдалд дотоод аудит хийх, зөвлөмж өгөх;	2-р улирал	Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйл ажиллагаа нь холбогдох журам, аргачлалын дагуу хэрэгжсэн байна.	ДАГ Ч.Цоодол
1.8	Хэрэглэгчийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд түүвэрчилсэн байдлаар дотоод аудит хийх, зөвлөмж өгөх;	3-р улирал	Хэрэглэгчийн өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна.	ДАГ Ч.Цоодол
1.9	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, холбогдох арга хэмжээг авч ажиллах;	жилдээ	Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах Ёс зүйн хороо, хяналт шалгалтын үр дүн сайжирсан байна.	Ёс зүйн хороо, ЗУГ
Хоёр. Төсөв, санхүү, зардлын ил тод байдлыг хангах чиглэлээр:				
2.1	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны зардлын төсөв, 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг цахим хуудсанд байршуулах;	1-р улирал	Байгууллагын үйл ажиллагааны зардлын төсөв болон өмнөх оны санхүүгийн тайланда хийсэн аудитын дүгнэлт олон нийтэд ил тод болсон байна.	ЗУГ М.Мандах
2.2	Байгууллагын 2021 оны ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг Эрчим хүчний яаманд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, байгууллагуудад тайлагнах, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг нийтлэх;	1-р улирал	Байгууллагын 2021 оны ажлын тайлан, төсвийн гүйцэтгэл нь салбарын удирдах дээд байгууллагад болон тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, байгууллагуудад танилцуулагдсан байна.	ЗУГ М.Мөнхтулга М.Мандах
2.3	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, шилэн дансны цахим хуудсанд худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллүүд, тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, орон тооны өөрчлөлт, аудитын тайлан, дүгнэлт зэрэг шаардлагатай мэдээллүүдийг цаг тухайд нь байршуулах;	саар бүр	Хуулийн хэрэгжилт хангагдаж, байгууллагын санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалтын талаарх мэдээлэл ил тод болсон байна.	ЗУГ Д.Болортuya
2.4	Хорооны хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тендер зарлан явуулах, шалгаруулах ажиллагааг ил тод, нээлттэй хэрэгжүүлэх;	тухай бүр	Бараа, ажил үйлчилгээ худалдан авах арга хэмжээ хуулийн дагуу, чанартай хэрэгжиж, мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй болно.	АА Г.Эрхэмбаяр ЗУГ М.Мөнхтулга

	Гурав. Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр:			
3.1	Шинээр олгосон эрчим хүчний тусгай зөвшөөрөл, аудитор, аудитын байгууллагын эрхийн гэрчилгээ, шинэчлэн баталсан хэрэглэгчийн үнэ тарифын талаарх мэдээллийг болон холбогдох дүрэм журмуудыг олон нийтэд ил тод нээлттэй байлгах, Хорооны цахим хуудсанд тогтмол байршуулах;	жилдээ	Тусгай зөвшөөрөл, эрх олголт, үнэ тарифын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангасан байна.	ТЗХГ, YTЗЗГ, ЭХХГ А.Бат-Эрдэнэ Ж.Мөнхзул Б.Энхжаргал Э.Болортuya
3.2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаа Хорооны цахим хуудсанд тогтмол байршуулах;	1-р улирал	Тусгай зөвшөөрөлтэй эрхэлж буй үйл ажиллагаа олон нийтэд мэдээлэгдсэн байна.	ТЗХГ А.Бат-Эрдэнэ
3.3	Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, байгууллагуудад 2022 онд хэрэгжүүлсэн хяналт шалгалтын төлөвлөгөө, хэрэгжүүлсэн шалгалтын дунг Хорооны цахим хуудсанд байршуулах;	1, 2, 4-р улирал	Хяналт, шалгалтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангасан байна.	ТЗХГ Л.Энхзаяа
3.4	ЭХЗХ-ны чиг үүргийн хүрээнд шинээр боловсруулсан, нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн, гадагш чиглэсэн дүрэм, журмын төсөлд сонирхогч бүлгийн саналыг авах, тусгах арга хэмжээ авах;	тухай бүр	Дүрэм, журмын төслүүд байгууллагын цахим хуудсанд ил тод байршсан байх ба сонирхогч этгээдүүд санал өгөх боломж бурдсэн байна.	ТЗХГ, YTЗЗГ, ЭХХГ Д.Ганзориг Б.Эрдэнэбулган Д.Наранцэцэг
3.5	Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын "E-license" цахим системийг төрийн мэдээллийн "Е-Монголиа", төрийн байгууллагуудын мэдээлэл солилцооны "ХҮР", "ДАН" цахим системтэй холбож шинэчлэх ажлыг дуусгах;	1, 2-р улирал	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн, техник, санхүү, эдийн засгийн болон үйлчлэх хүрээний мэдээллийг агуулсан цогц программ хангамжийг хөгжүүлж нэвтрүүлсэн байна.	ТЗХГ Б.Бат-Эрдэнэ
3.6	Эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, нөхцөл, шаардлагын биелэлтийг дүгнэх ажлыг цахим системийг ашиглан хэрэгжүүлэх, дунг мэдээлэх;	жилдээ	Хорооны тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаа нээлттэй, ил тод явагдана.	ТЗХГ Б.Бат-Эрдэнэ
3.7	Аймаг, нийслэлийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлүүдийн болон тэдгээрийн харьялах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг авах, хянах цахим мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх;	2, 3-р улирал	Нийслэлийн болон 21 аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд цахимаар хяналт тавих, мэдээ, тайлан авах, орон нутаг дахь ТЗЭ компаний, аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэсэн байна.	ХОНХ Д.Бат-Эрдэнэ ЗУГ Б.Батбаяр
3.8	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх;	улирал бүр	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	ХОНХ Н.Болормаа

3.9	Ажилтны ХАСУМ хянасан дүгнэлт, сул орон тооны зар, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг байгууллагын шилэн дансанд байршуулах;	сар бүр	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	ЗУГ Д.Мөнхболд
Дөрөв. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах чиглэлээр:				
4.1	Иргэд, хэрэглэгчдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч хуульд заасан хугацаанд шийдвэрлэх;	жилдээ	Хэрэглэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байна.	ХОНХ Д.Бат-Эрдэнэ
4.2	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фейсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх;	жилдээ	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилж соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	ЗУГ М.Мөнхтулга Б.Цоожчулуун-цэцэг
4.3	Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах;	жилдээ	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилж соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	ЗУГ М.Мөнхтулга Б.Цоожчулуун-цэцэг
4.4	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	жилдээ	Авлигын эсрэг хууль тогтоомжийг ажилтнуудад сурталчилсан байна.	ЗУГ М.Мөнхтулга
4.5	Эрчим хүчний хэрэглэгчид, олон нийтийг салбарын болон зохицуулалтын үйл ажиллагаа, хэрэглэгчийн үнэ тарифын талаарх мэдээ, мэдээллээр хангах зорилгоор Хорооны цахим мэдээллийн веб сайтад холбогдох мэдээллүүдийг тухай бүр нийтлэх;	жилдээ	Хорооны зохицуулалтын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ойлгомжтой болоход дэмжлэг болсон байна.	Б.Цоож-чулуунцэцэг, газар, хэлтсийн ахлах мэргэжилтнүүд
4.6	Авлигын эсрэг хууль тогтоомж, мэдүүлэг, мэдэгдэл гаргах талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхэд холбогдох мэдээлэл, сурталчилгаа, сургалт хийх ажлыг зохион байгуулах;	жилдээ	Ажилтан, албан хаагчид ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ойлголт, мэдлэгтэй болно.	ЗУГ М.Мөнхтулга Т.Батзаяа
4.7	Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар АТГ-т хүргүүлэх, тус газраас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад ажилтнуудыг хамруулах;	2-4-р улирал	Холбогдох ажилтнууд АТГ-аас зохион байгуулах сургалтад хамрагдсан байна.	ЗУГ М.Мөнхтулга
4.8	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг иргэд, хүүхэд залууст хүргэх;	жилдээ	Авлигын эсрэг сургалт, сурталчилгааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байна.	ЗУГ Б.Цоож-чулуунцэцэг

	Тав. Бусад			
5.1	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх;	жилдээ	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд холбогдох шийдвэрүүдийг биелүүлж хариу мэдэгдсэн байна.	АА Г.Эрхэмбаяр ЗУГ М.Мөнхтулга
5.2	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдэж ажиллах;	жилдээ	Байгууллагын зүгээс авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлсэн байна.	ЗУГ М.Мөнхтулга
5.3	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	жилдээ	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлсэн байна.	ЗУГ М.Мөнхтулга, холбогдох ажилтнууд
5.4	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	жилдээ	Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах арга хэмжээг зохион байгуулсан байна.	АА Г.Эрхэмбаяр ЗУГ М.Мөнхтулга
5.5	Авлигын эсрэг байгууллагын соёлыг төлөвшүүлэх, удирдлагын манлайлал үзүүлэх, санаачилга өрнүүлэх.	жилдээ	Авлигын эсрэг үйл ажиллагааг байгууллагын удирдлагын зүгээс эрчимжүүлсэн байна.	Хорооны дарга А.Тлейхан ЗУГ М.Мөнхтулга
5.6	Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар байгууллагын ажилтнуудад зөвлөмж, арга зүйн туслалцаа үзүүлэх;	тухай бүр	Авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүн дээшилнэ.	ЗУГ М.Мөнхтулга Т.Батзаяа

Танилцсан:


Ажлын албаны дарга



Г.Эрхэмбаяр

Төлөвлөгөө боловсруулсан:

Эрх бүхий албан тушаалтан



М.Мөнхтулга